

МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН НУТГААР  
ДАМЖИН ТЭЭВЭР ХИЙЖ, ДАЛАЙД ГАРАХ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Зас-  
гийн газар /цаашид Хэлэлцэн тохирогч Талууд гэж нэрлэнэ/,

хоёр орны уламжлалт нөхөрсөг харилцаа, итгэлцэл, төрөл бү-  
рийн хамтын ажиллагааг үндэс болгон,

далайд гарцгүй улсын онцгой эрх ашиг, хэрэгцээг харгал-  
зан үзэх ёстойг хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим,  
хэм хэмжээг эрхэмлэдгээ нотлон,

олон улсын худалдааг өргөтгөн хөгжүүлэхэд дэмжлэг үзүү-  
лэхийг эрмэлзэн,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.Үүнд:


Нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хувьд:

а/"далайд гарцгүй улс" гэж Монгол Улсыг хэлнэ;

б/"дамжин өнгөрөх улс" гэж Оросын Холбооны Улсыг  
хэлнэ;

в/"дамжин өнгөрөх хөдөлгөөн" гэж далайд гарцгүй ул-  
сын хүмүүс, тээш, ачаа, түүнчлэн бараа, илгээлт, шууданг да-  
лайд гаргах зорилгоор дамжин өнгөрөх улсын нутгаар дамжуулан  
өнгөрүүлэхийг хэлэх бөгөөд ачааг шилжүүлэн ачих, хадгалах,  
хэсэглэх, нэгтгэх буюу тээврийн хэрэгслийг сэлгэх эсхүл



эдгээр ажиллагааг гүйцэтгэхгүйгээр дамжин өнгөрөх нь далайд гарцгүй улсын нутаг дэвсгэрт эхэлж, дуусах нийт замын зөвхөн хэсэг байна.

г/ "тээврийн хэрэгсэл" гэх төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, авто тээврийн хэрэгсэл, далайн болон гол мөрний хөлөг онгоцныг хэлнэ. Хэлэлцэн тохирогч Талууд харьцан тохиролцож тээврийн бусад төрлийг тээврийн хэрэгсэлд хамруулж болно.

Хоёрдугаар зүйл

Дамжин өнгөрөх улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудад тулгуурлан тухайн улсаас тогтоосон журмын дагуу далайд гарцгүй улсад дор дурдсан эрх олгоно:

а/ далай руу болон далайгаас дамжин өнгөрөх улсын нутгаар энэхүү Хэлэлцээрийн заалтуудын дагуу дамжин өнгөрөх хөдөлгөөнийг чөлөөтэй гүйцэтгэх,

б/ далайн боомтуудыг ашиглах, дамжин өнгөрөх улсын довтоодын болон нутгийн усаар далайд гарцгүй улсын далбааг мандуулсан хөлөг онгоц нэвтрэн өнгөрөх,

г/ ачаагаа хадгалах, шилжүүлэн ачих, хэсэглэх, нэгтгэх.

Гуравдугаар зүйл

Далайд гарцгүй улсын далбааг мандуулсан хөлөг онгоцууд дамжин өнгөрөх улсын далайн боомтуудад гуравдагч улсын хөлөг онгоцонд олгодогтой ажил эрх эцэслэнэ.

Бүртгэлийн дугаар 161  
МОНГОЛ УЛСЫН  
МААД УХААМБЛААНЫ ТӨВ АРХИВ  
ХУУЛЬ АР ҮНЭН  
Хууль зөр хяналтын үйлчилгээ  
01  
Гарын үсэг, хатуу гэдэвний хэргийг  
2014 оны 3 сарын 4 өдөр

3.

Нөрөвдүгээр зүйл

Далайд гарцгүй улс энэхүү Хэлэлцээрийн хоёрдугаар зүйлд заасанчлан дамжин өнгөрөх хөдөлгөөнийг тухайн хоёр орны тээврийн хэрэгсэл, түүнчлэн Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын тохиролцсоны дагуу гуравдагч улсын тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

Тавдугаар зүйл

1. Далайд гарцгүй улс дамжин өнгөрөх улсын нутгаар хүмүүс, тээш, ачаагаа дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон тээврийн зардлыг хариуцна.

2. Дамжин өнгөрөх улс өөрийн нутаг дэвсгэрээр зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аль болох дөт замыг тогтоож өгөх бөгөөд дамжин өнгөрөх улсаас тийнхүү үзүүлж буй туслалцаа, үйлчилгээтэй холбогдсон зардлыг далайд гарцгүй улс өөрөө хариуцна.

3. Дамжин өнгөрөх хөдөлгөөнд дамжин өнгөрөх улсаас үзүүлж буй үйлчилгээнд дамжин өнгөрөх улсын дотоодын тээврийн тариф, хураамж болон хоёр улсын нэгдэж орсон олон улсын хэлэлцээрээр тогтоосон тариф, хураамжаас илүүгүй, нэн хөнгөлөлттэй тариф тогтоож, хураамж ногдуулна.

4. Монголын болон Оросын холбогдох байгууллагууд энэхүү хэлэлцээртэй холбогдсон бүх төлбөр тооцоог чөлөөтэй хөрвөх валютаар гүйцэтгэнэ. Хоёр улсын холбогдох байгууллагууд төлбөр тооцоогоо өөр валютаар буюу өөр хэлбэрээр хийх талаар тохиролцож

Зургадугаар зүйл

1. Дамжин өнгөрөх улс далайд гарцгүй улсын дамжин өнгөрөх

...гийн дугаар болно. 101  
МОНГОЛ УЛСЫН  
ХААД ХАРИУЦААНЫ ТӨВ АРХИВ  
ХУУЛЬ АР ҮНЭН  
М 3 4

хөдөлгөөнийг саатуулахгүй байх, техникийн чанартай бусад бэрхшээл гаргахгүй байх талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна.

2. Энэхүү зүйлийн I-д дурдсан саатал, бэрхшээл гарвал тэдгээрийг даруй арилгах зорилгоор Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд шуурхай зөвлөлдөж, хамтран ажиллана.

#### Долдугаар зүйл

I. Далайд гарцгүй улсын дамжин өнгөрөх хөдөлгөөнд тавих гаалийн болон бусад төрлийн хяналтыг дамжин өнгөрөх улсын гаалийн болон хяналтын бусад байгууллага хууль тогтоомжийнхоо дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ.

2. Далайд гарцгүй улсын ачаа, тээврийн хэрэгсэлд ер нь бол зөвхөн гаалийн гадаад үзлэгийг хийнэ. Харин нийгмийн дэг журам, тухайлбал нийгмийн аюулгүй байдал, ёс суртахуун, эрүүлийг хамгаалахтай холбогдсон учир шалтгаанаар, эсвэл байгаль орчин, соёлын өв, үйлдвэр, худалдаа, оюуны өмчийг хамгаалах үүднээс шаардлага гарвал бүрэн буюу хэсэгчилсэн дотоод үзлэг хийж болно.

3. Далайд гарцгүй улсын ачаа тээвчид гаалийн бүрдүүлэлт хийхтэй холбогдсон хураамлаас өөр гаалийн болон бусад ямарваа татвар хураамж ногдуулахгүй.

#### Наймдугаар зүйл

I. Далайд гарцгүй улс ачаагаа хадгалах, шилжүүлэн ачих, хэсэглэх, нэгтгэх зорилгоор дамжин өнгөрөх улсын далайн боомтуудад тусгай бүстэй байж болно.

МОНГОЛ УЛСЫН  
ТӨВ АРХИВ  
ХУУЛЬ АР ҮНЭН

М 3

434  
 01  
 ХҮҮЛГААР  
 ХАМГААГАХ  
 ТӨСӨМӨР  
 ХАМГААГАХ  
 ТӨСӨМӨР

Энэхүү Хэлэлцээрийг 10 жилийн хугацаагаар байгуулж байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч нь тэд Хэлэлцээрийн зохих хугацааг дуусгахад 12 сарын өмнө түүний үйлчилгээг зогсоох тухай

Арван хоёрдугаар зүйл

Хийгдсэн байна.

Энэхүү Хэлэлцээрт оруулах ажил, өөрчлөлт, хөрөнгө оруулалт, тохирогч талууд тохиролцоо бөгөөд тэдгээрийг бичгээр

Арван нэгдүгээр зүйл

маар зохиуула.

Энэхүү Хэлэлцээрийг тасаргах, хэрэгжүүлэх тусгай Хэлэлцэн тохирогч талуудын хооронд гарсан маргааныг хэлэлцэний за-

Арвандугаар зүйл

тэй өгч арга хэмжээг авах эрхтэй.

Тийш өгч өөрсөд байдалд хохирогчийг байхад чиглэсэн шаардлага-  
 сон эрх, болголт нь хамжин өнгөдх үлсн хууль ёсны эрх аш-  
 ралжүүлэхээ энэхүү Хэлэлцээрт тэдгээрийг үлсн олго-  
 Ламжин өнгөдх үлс өөрийн нутаг дэвсгэрт бүрэн эрхээ хэ-

Бөхдүгээр зүйл

болно.

2. Давалд тэдгээрийг үлс ламжин өнгөдх үлсн нутаг дэвсгэрт өөрийн тэдгээрийг байгуулалтын төлөөлөгчийн газруудтай байх

Энэхүү болголт хэрэгжүүлэх тусгай хууль ёсны эрх бү-  
 хий байгуулалтууд тусгайлан тохиролцож байна.

6.


хүсэлтээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талд бичгээр эс мэдэгдвэл энэхүү Хэлэлцээрийн хугацаа тав таван жилээр аяндаа сунгагдаж байх болно.

Арван гуравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр түүнд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээрийг 1992 оны 10 дугаар сарын 19 -ны өдөр монгол, орос хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд хоёр эх бичвэр нь адил хүчинтэй байна.

  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛӨН

  
ОРОСЫН ХОЛБОСНЫ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛӨН

